



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (157)

Монгол Улсын хууль:

- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны тавдугаар сарын 31

№ 20 (157)

Гарчиг

Нэг. Монгол Улсын хууль

- | | |
|--|-----|
| 228. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай (2000-5-12-ны хууль) | 421 |
| 229. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай (1993 оны) хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2000-5-12-ны хууль) | 427 |
| 230. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 160 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай (2000-5-12-ны хууль) | 427 |

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

- | | | |
|--|-----------|-----|
| 231. Монгол төлбөрийн хэмжээг тогтоох тухай | Дугаар 42 | 427 |
| 232. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай | Дугаар 46 | 428 |
| 233. Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай | Дугаар 50 | 430 |
| 234. Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашины зардал хэмнэх тухай | Дугаар 51 | 431 |

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт

- | | | |
|---|-----------|-----|
| 235. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай | Дугаар 03 | 431 |
|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд жарш аливаа үйл ажиллагааг хориглон хязгаарлах, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлж хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж

2.1.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэхүү хууль нь зах зээлийн өрсөлдөөнд оролцогч хуулийн этгээд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад нэгэн адил үйлчилнэ.

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаас, санхүүгийн зах зээл болон зар сурталчилгааны үйл ажиллагаа нь өрсөл-

дөөнд харш үр дагавар үзүүлэх буюу үзүүлж болзошгүй бол энэ хуулийг мөрднө.

3.3.Оюуны өмчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд хийсэн үйл ажиллагаа, үүссэн нөхцөл байдлыг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."бараа бүтээгдэхүүн" гэж зах зээлд нийлүүлж байгаа бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг;

4.1.2."зах зээл" гэж тодорхой бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт бодитой яваг-

даж байгаа нутаг дэвсгэрийг;

4.1.3."санхүүгийн байгууллага" гэж зээлийн болон даатгалын байгууллага, түүнчлэн үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн зуучлагчийг;

4.1.4."өрсөлдөгч" гэж тухайн төрлийн бараа бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа этгээдийг.

5 дугаар зүйл.Зах зээлд ноёрхох байдал

5.1.Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ.

5.2.Давамгай байдлаа хууль бусаар ашиглах, өрсөлдөгчөө зах зээлд ороход саад учруулах, өрсөлдөөнийг болон хэрэглэгчийг хясан боогдуулахыг ноёрхох

үйл ажиллагаанд тооцож, ийм төрлийн үйл ажиллагаа явуулсан этгээдийг ноёрхогч гэж үзнэ.

5.3.Тухайн бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал, хамгийн бага байх зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийг зүй ёсны монополь гэж үзнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Давамгай байдалтай аж ахуйн нэгжээс шударга өрсөлдөөнд саад учруулахыг хориглох

6 дугаар зүйл.Давамгай байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглах

6.1.Давамгай байдалтай аж ахуйн нэгж дангаараа дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

6.1.1.зохиомлоор барааны хомсдол бий болгож үнийг өсгөх зорилгоор өөрийн барааны үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох, хэмжээг хязгаарлах;

6.1.2.зах зээлд давамгай байдлаа ашиглаж хэрэглэгчдээс борлуулалтын

нэмэлт нөхцөлийг шаардах, бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах;

6.1.3.бусад аж ахуйн нэгж зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор бараа бүтээгдэхүүнээ зардлаас доогуур үнээр борлуулах;

¹ Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл"-ийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.



6.1.4.үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад этгээдийг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор тэдгээртэй аж ахуйн харилцаа тогтоохоос үндэслэлгүйгээр татгалзах, тэдгээрт үндэслэлгүй шалгуур үзүүлэлт тогтоох;

6.1.5.бараа бүтээгдэхүүн борлуулахдаа иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах;

6.1.6.хэрэглэгчид тухайн барааг дахин борлуулах үнэ, нутаг дэвсгэрийг тогтоож өгөх;

6.1.7.өөрийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахуулахгүй байх болзол тулгах;

6.1.8.тухайн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг бууруулахад хүргэж болох бага үнээр уг бараа бүтээгдэхүүнийг өөртөө худалдахыг бусдаас шаардах;

6.1.9.хэрэглэгч болон өрсөлдөгчөөс санхүүгийн хэрэгсэл, эд хөрөнгө, тэдгээрийн эрх, ажиллах хүч зэргийг өөртөө шилжүүлэхийг үндэслэлгүйгээр шаардах;

6.1.10.өрсөлдөгчөө хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, татан буулгахыг шаардах;

6.1.11.гэрээний зүйлд хамаарахгүй болон гэрээт талд ашиггүй нөхцөлийг гэрээнд тусгахыг тулган шаардах.

7 дугаар зүйл. Давамгай байдалтай өрсөлдөгч аж ахуйн нэгж өрсөлдөөнд саад учруулсан хэлцэл хийхийг хориглох

7.1.Хамтдаа давамгай байдалтай өрсөлдөгч аж ахуйн нэгжүүд өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор дараахь шийдвэр, хэлцэл, тохиролцоо байгуулахыг хориглоно:

7.1.1.бараа бүтээгдэхүүний үнийг харилцан тохиролцох, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээг хязгаарлах;

7.1.2.зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, хэрэглэгчээр хуваарилах;

7.1.3.өрсөлдөөнд чухал ач холбогдол

бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;

7.1.4.урдалдаант шалгалт буюу дуудлага худалдаанд үнийг урьдчилан тохиролцож оролцох, бусад өрсөлдөгчөө дээрх үйл ажиллагааны бодит нөхцөлөөс төөрөгдүүлэх, тэдэнд дарамт, шахалт үзүүлэх;

7.1.5.аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах;

7.1.6.барааг гуравдагч этгээдэд худалдах болон худалдан авахыг хязгаарлах.

8 дугаар зүйл. Өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагын албан тушаалд ажиллахыг хориглох

8.1.Давамгай байдалтай аж ахуйн нэгжийн удирдлага өрсөлдөгч бусад аж

ахуйн нэгжийн удирдлагын албан тушаалд хавсарч ажиллахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Өрсөлдөгчөө эрхшээлдээ авахыг хориглох

9.1.Давамгай байдалтай аж ахуйн нэгж зах зээлд ноёрхон үйл ажиллагаа явуулах зорилгоор өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахыг хориглоно.

9.2.Улсын эдийн засагт тэргүүлэх чиглэлийн болон хүн амд нэн шаардлагатай

барааны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг ашигтай тал нь өрсөлдөөнд учруулах хохирлоос илүүтэй байх нь нотлогдсон тохиолдолд энэ хуулийн 9.1-д заасныг хамааруулахгүй байж болно.

10 дугаар зүйл. Өрсөлдөөнд харш үйл ажиллагаа

10.1.Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд өрсөлдөөнд харш дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

10.1.1.өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

10.1.2.өөрийн болон өрсөлдөгчийн үйлдвэрийн газар, түүний байршил, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх;

10.1.3.өөрийн барааг бусдын бараатай ижилсгэн сурталчлах;

10.1.4.ивээн тэтгэгч этгээд ивээн тэтгүүлж байгаа этгээдээс өрсөлдөөнд харш

аливаа үйл ажиллагаа явуулахыг шаардах;

10.1.5.бараа бүтээгдэхүүн сурталчлахаар өгсөн захиалгын хугацаа, дарааллыг зөрчих;

10.1.6.бусдын барааны тэмдэг, шошго, үйлдвэрийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, түүнчлэн барааны оноосон нэр, баглаа бодолдыг хуулбарлах;

10.1.7.патент эзэмшигч, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, худалдааны мэдээлэл, нууцыг худалдах, нийтлэх, бусдад тараах. Энэ нь патентын болон зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжоор хязгаарлагдаагүй, зах зээлд чөлөөтэй худалдагдаж байгаа барааг дуурайлган дахин угсран бүтээхэд хамаарахгүй;

10.1.8.барааны чанарын доголдол, аюултай шинж чанарыг нуун дарагдуулах.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн шийдвэр гаргахыг хориглох

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн шийдвэр гаргахыг хориглох

11.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрлийн /лиценз/ эрх олгохыг хориглоно.

11.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараахь шийдвэр гаргахыг хориглоно:

11.2.1. аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;

11.2.2. аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд бараагаа нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;

11.2.3. аж ахуйн үйл ажиллагааны аливаа чиглэлээр тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан.

11.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомжид зааснаас

бусад тохиолдолд хоорондоо болон аль нэг аж ахуйн нэгжтэй тохиролцон дараахь шийдвэр гаргахыг хориглоно:

11.3.1. бараа бүтээгдэхүүний үнийг бууруулсан, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн;

11.3.2. зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн;

11.3.3. аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд тухайн зах зээлд гарч ирэхийг хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан зайлуулахад чиглэсэн;

11.3.4. аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүний бусад байгууллага, аж ахуйн нэгж, үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд зээлээр олгоход чиглэсэн.

11.4. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас учирсан хохирлыг нөхөхөд зориулж Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагаас зээл олгох, тусламж үзүүлэхийг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага

12 дугаар зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба

12.1. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба /цаашид "Хянан зохицуулах алба" гэх/ нь шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, өрсөлдөөнд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гаргах, аж ахуйн нэгжийн давамгайл болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох болон шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагад оруулах чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

12.2. Хянан зохицуулах алба нь зөвлөлтэй байна:

12.2.1. Зөвлөл нь дарга, дөрвөн гишүүнээс бүрдэнэ. Хянан зохицуулах албаны дарга нь зөвлөлийн дарга байна. Зөвлөлийн гишүүд орон тооны бус байна;

12.2.2. Зөвлөлийн гишүүдийг хянан зохицуулах албаны даргын санал болгос-

ноор Засгийн газар томилж, чөлөөлнө;

12.2.3. Зөвлөл нь энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.2, 15.2-т заасан асуудлаар шийдвэр /тогтоол/ гаргана.

12.3. Хянан зохицуулах алба нь энэ хуульд заасан үндсэн чиг үүргээ төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас хамааралгүйгээр бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

12.4. Хянан зохицуулах албанд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутагт улсын байцаагч ажиллана.

12.5. Хянан зохицуулах албаны дарга улсын ерөнхий байцаагч байна. Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг Хянан зохицуулах албаны даргын саналыг үндэслэн Сангийн сайд томилж, чөлөөлнө.

12.6. Хянан зохицуулах албаны үйл ажиллагааны стратеги, бүтцийг Засгийн газар баталж, төсвөөс санхүүжүүлнэ.

12.7. Хянан зохицуулах алба үйл ажиллагаагаа жил бүр Засгийн газарт тайлагнана.



13 дугаар зүйл. Улсын байцаагчийн бүрэн эрх

13.1. Хянан зохицуулах албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай¹ хуулийн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэг-

жүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдана.

14 дүгээр зүйл. Хянан зохицуулах албаны бүрэн эрх

14.1. Хянан зохицуулах алба нь чиг үүргийнхээ дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллагад шалгаж дүгнэлт гаргах;

14.1.2. аж ахуйн нэгжийн тухайн зах зээлд давамгайлах болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох, бүртгэх, судалгаа гаргах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих. Аж ахуйн нэгжүүдийн давамгай болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох журмыг Засгийн газар батална;

14.1.3. давамгай байдлаа хууль бусаар ашиглаж байгаа аж ахуйн нэгжийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулахыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлагаас шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг зогсоох;

14.1.4. шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хууль бус ажиллагааг таслан зогсоох, хориглох, хязгаарлах, захиргааны шийтгэл ногдуулах;

14.1.5. өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл, бичиг баримтыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжээс гаргуулан авах, түүнд дүн шинжилгээ, боловсруулалт хийх, дүгнэлт гаргах;

14.1.6. шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлэх;

14.1.7. өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах талаар санал боловсруулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

14.1.8. өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрээ нийтэд мэдээлэх;

14.1.9. мэргэжлийн хяналт шалгалтын болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудыг хяналт шалгалтын болон дүгнэлт гаргах ажилд татан оролцуулах.

14.2. Улсын байцаагчийн тавьсан актыг шаардлагатай бол Зөвлөл хянаж шийдвэр гаргана.

15 дугаар зүйл. Аж ахуйн нэгжүүдийг өөрчлөн байгуулах /нэгдэх, нийлэх/-д хяналт тавих

15.1. Давамгай байдалтай аж ахуйн нэгж өрсөлдөгч аж ахуйн нэгжтэй нэгдэх, нийлэхийг хориглоно.

15.2. Аж ахуйн нэгжүүдийн нэгдэх, нийлэх, өөрчлөн байгуулах ажиллагааг Хянан зохицуулах албаны гаргасан дүгнэлтийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ. Хянан зохицуулах алба нь холбогдох материалыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дүгнэлтийг бичгээр гаргана. Шаардлагатай гэж үзвэл Хянан зохицуулах алба энэ

хугацааг 14 хоног хүртэл сунгаж болно.

15.3. Хянан зохицуулах алба нь аж ахуйн нэгжүүдийг нэгдэх, нийлэх, хувьчлах замаар өөрчлөн байгуулснаар зах зээлд ноёрхох байр суурь эзлэн өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ гэж үзсэн тохиолдолд аж ахуйн нэгжүүдийг ийнхүү өөрчлөн байгуулахыг татгалзаж болно.

15.4. Татгалзсан дүгнэлт нь уг аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгэхгүй байх үндэслэл болно.

¹ Төрийн хяналт шалгалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны 4 дүгээрт нийтлэгдсэн.



ТАВДУГААР БҮЛЭГ

Зүй ёсны монополийг төрөөс зохицуулах

16 дугаар зүйл. Зүй ёсны монополийн үйл ажиллагааг зохицуулах

16.1. Хянан зохицуулах алба зүй ёсны монополийн үйл ажиллагаанд дараахь зохицуулалт хийнэ:

16.1.1. зах зээлд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан зөвшөөрөл олгох;

16.1.2. бодит зардлыг харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид борлуу-

лах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох;

16.1.3. өрсөлдөөн үүсэх боломж бүрдсэн буюу зүй ёсны монополийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан тохиолдолд өрсөлдөөн бий болгох шаардлагыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

17 дугаар зүйл. Гомдол гаргах

17.1. Хянан зохицуулах албаны хууль зөрчигчид хүлээлгэсэн хариуцлагыг үл шийдвэрийг хууль бус гэж үзсэн этгээд энэ тухай гомдлоо шүүхэд гаргаж болно.

17.2. Энэ хуулийн 18.2-т заасны дагуу гүйцэтгүүлнэ.

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай этгээдээр хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

18.2. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хянан зохицуулах албаны улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна.

18.2.1. энэ хуулийн 6, 7, 10 дугаар зүйл, 9.1-д заасныг зөрчсөн аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах, зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсоох, тусгай зөвшөөрлийн эрхийг хууль тогтоомж зөрчихөд ашигласан бол түүнийг хүчингүй болгуулах талаар саналыг зөвшөөрөл олгосон холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

18.2.2. энэ хуулийн 8 дугаар зүйл, 15.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгож, зөрчил гаргахаас өмнөх байдлыг сэргээн тогтоох;

18.2.3. энэ хуулийн 11.1, 11.2, 11.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ (1993 ОНЫ) ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 160 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 160 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 3 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас тогтоосон болзлын дагуу 2000 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг 651000 (зургаан зуун тавин нэгэн мянга) төгрөг байхаар тогтоосугай.

2. Мөнгөн төлбөрийг зохих журмын дагуу хураах зохион байгуулалтын арга хэм-

жээ авахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мөнгөн төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Батлан хамгаалахын
сайд Ш.ТҮВДЭНДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 3 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай

Үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэх, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөрөнгө оруулалт, зээлийн үр ашигт урьдчилсан үнэлгээ хийх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөрөнгө оруулалт, зээлийн үр ашгийг дээшлүүлэх арга зам, бизнесийн болон маркетингийн төлөвлөгөө боловсруулах, төсөл зохиох зэрэг чиглэлээр аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтэнг хамруулсан сургалт, семинар, сэдэвчилсэн уулзалт зохион байгуулж ажиллахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт

даалгаж, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэлд зөвлөсүгэй.

3. Хөрөнгө оруулалт, зээлийн үр ашигт урьдчилсан үнэлгээ хийх ажлыг Монгол банктай хамтран зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт мэдээлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд

Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 2000 оны 46 дугаар тогтоолын хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗЭЭЛИЙН ҮР АШИГТ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1. Энэхүү журмын зорилго нь улсын эдийн засагт нөлөө бүхий үр ашигтай ажиллаж байгаа үндэсний томоохон аж ахуйн нэгжийн зүгээс гадаадын хөрөнгө оруулалт, зээл авахаар тохирсон нөхцөлд мэргэжлийн шинжээчдийг томилон үр ашгийн

урьдчилсан үнэлгээ хийж тухайн хөрөнгө оруулалт, зээл үр ашигтай болох нь нотлогдсон тохиолдолд Засгийн газар, банкнаас төлбөрийн баталгаа гаргах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Хөрөнгө оруулалт, зээлийн үр ашигт үнэлгээ хийх

2. Үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт хийх, зээл авахаар гадаад орон, гадаадын хөрөнгө оруулагч болон банктай тохирсон үндэсний томоохон үйлдвэрийн гэрээний урьдчилсан нөхцөл, хүсэлтийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам хүлээн авч Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран эдгээр хүсэлтээс сонголт хийж холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлнэ.

в/хөрөнгө оруулалт, зээлийн урьдчилсан гэрээний төсөл; г/зээлийг ашиглах, хөрөнгө оруулалт хийх гэж буй үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийн тооцоо, зээл төлөлтийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгө; д/бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, борлуулалтын төлөвлөгөө.

3. Авах гэж буй хөрөнгө оруулалт, зээлийнхээ үр ашигт урьдчилсан үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргасан үйлдвэр нь дор дурдсан баримтыг бүрдүүлсэн байна:

а/тухайн байгууллагын бизнес төлөвлөгөө;

б/санхүүгийн үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн тайлан;

4. Үг хүсэлтийг гаргасан үйлдвэрийн хөрөнгө оруулалт, зээлийн үр ашигт урьдчилсан үнэлгээ хийх чадвар бүхий мэргэжлийн шинжээчдийг оролцуулсан комисс (цаашид "комисс" гэнэ)-ыг Сангийн сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгч хамтарсан тушаалаар томилж ажиллуулна.



5. Хүсэлт гаргасан тухайн үйлдвэрийн хөрөнгө оруулалт, зээл авахтай холбогдсон материалыг комисс 2 долоо хоногийн дотор судалж тухайн хөрөнгө оруулалт, зээлийн хүүгийн нөхцөл, үр ашиг, үйлдвэрлэлийн өсөлт, техник, технологийн шинэчлэлт, бүтээгдэхүүний зах зээл, зээлийн эргэж төлөгдөх үндэслэл, төлбөрийн баталгаа гаргах хөрөнгө зэрэгт үнэлгээ хийж, дүгнэлт гаргана. Комисс үнэлгээ хийж, дүгнэлт гаргах явцад тухайн байгууллагын бизнес төлөвлөгөө, маркетингийн стратеги төлөвлөлт болон

байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалтай биечлэн танилцсан байна. Комисс нь хөрөнгө оруулалт, зээл, зээлийн хүү, төлөх хугацаа зэрэг асуудлаар гэрээний нөхцөлийг өөрчлөх санал гаргаж болно. Комисс нь Сангийн яамыг түшиглэн ажиллана.

6. Комисс нь хөрөнгө оруулалт, зээл авахтай холбогдсон үнэлгээ, дүгнэлтээ Сангийн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Монгол банкны Ерөнхийлөгчид дүгнэлт гаргаснаас хойш 10 хоногийн дотор багтаан танилцуулна.

Гурав. Хөрөнгө оруулалт, зээлд төлбөрийн баталгаа гаргуулахаар шилжүүлэх

7. Аж ахуйн нэгжийн зүгээс авахаар тохирсон гадаадын хөрөнгө оруулалт, зээл үр ашигтай болох нь комиссын үнэлгээ, дүгнэлтээр тогтоогдсон нөхцөлд Сангийн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам холбогдох материалыг бүрдүүлэн Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

8. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл авахаар тохирсон аж ахуйн нэгжийн санал, комиссын үнэлгээ, дүгнэлтийг Засгийн газар дэмжсэн нөхцөлд тухайн хөрөнгө оруулалт, зээл авахыг хүсэгч үйлдвэр хөрөнгө оруулалт, зээлийн гэрээгээ байгуулахаар

зохих хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу холбогдох арилжааны банк, зээл олгох, хөрөнгө оруулалт хийх гадаадын харилцагчтайгаа эцэслэн тохиролцоно.

9. Тухайн үйлдвэр нь хөрөнгө оруулалт, зээлийн гэрээгээ эцэслэн тохиролцсоны дараа холбогдох материал, комиссын дүгнэлт, Засгийн газраас дэмжсэн шийдвэрийн хамт Монгол банк буюу арилжааны банкинд хүргүүлж төлбөрийн баталгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргуулна. Шаардлагатай гэж үзвэл Засгийн газар төлбөрийн баталгаа гаргаж болно.

Дөрөв. Баталгаа гаргуулагчийн үүрэг

10. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл авсан аж ахуйн нэгж нь өөрийн өмчлөлд байгаа хөрөнгө, хувьцаа, дүрмийн сангийн ногдол хувь зэрэг хөрөнгөөр төлбөрийн баталгаа гаргуулж, тухайн хөрөнгө оруулалт, зээл, түүний хүүг батлагдсан хугацаанд

төлөх үүрэгтэй.

11. Хөрөнгө оруулалт, зээл, түүний хүүг батлагдсан хугацаанд төлөөгүй аж ахуйн нэгжийн удирдлага холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Тав. Тавих хяналт

12. Сангийн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Монгол банк нь гадаадын хөрөнгө оруулалт, зээл авсан үйлдвэрийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, зээлийн үр ашиг, зээл, зээлийн хүүгийн төлөлтийн бай-

далд хяналт тавина.

13. Хяналт тавих явцад зээлийн гэрээгээ зөрчсөн үйлдвэрийн удирдлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх санаачилгыг гаргаж хэрэгжүүлнэ.



2000 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанарыг сайжруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд даалгах нь:

а)"Ноолуур" хөтөлбөрийг 2000 оны П улиралд багтаан боловсруулсугай;

б)ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологийн түвшин, бүтээгдэхүүний чанарыг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран 2000 оны 5 дугаар сард багтаан аттестатчилах арга хэмжээ авсугай;

в)Баяндэлгэр, Эрчим, Буурал, Өлгийн улаан зэрэг нутгийн шилмэл омгийн ямааг сонгон үржүүлэх, сайжруулагчаар ашиглах бүс нутгийг тогтоосугай.

2.Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн экспортыг сайн дурын хязгаарлалтад хамруулах, түүхий эд экспортлох эрхийг багцлан дуудлага худалдаагаар олгох тогтолцоо бий болгох боломжийг судлан санал боловсруулж энэ оны П улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт даалгасугай.

3.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанарын стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, экспортод гаргаж буй түүхий эдэд тавих мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтыг бүх шатанд сайжруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

4.Ноолуурын салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

5.Ноолуур, ямааны арьсыг гүний болон байнгын ажиллагаатай гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр гаргахыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга Т.Лхагваад даалгасугай.

6.Мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа, гаалийн бүрдүүлэлтгүй хууль зөрчин улсын хилээр гаргахыг завдсан болон гаргасан түүхий эдийн тухай мэдээллийг холбогдох байгуул-

лагад өгсөн, зөрчлийг илрүүлсэн байгууллага, албан тушаалтан, иргэдэд зөрчлийн улмаас хураагдсан түүхий эдий орлого болон борлуулалтын орлогыг дүнгийн 15 хүртэл хувийг урамшуулал бс.лго олгож, 15 хувийг орон нутгийн төсөвт олго журмыг 4 дүгээр сарын эхний 15 хоног баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

7.Аймаг, сумын Засаг дарга нарт даалгах нь:

а)ямааны үүлдэрлэг байдал, сүргий бүтцийг нарийвчлан тогтоож, нарийн ноолуу бүхий цөм сүргийг бүрдүүлэх, бүртгэ мэдээллийн сүлжээ бий болгох арга хэмжээ авсугай;

б)гойд ашиг шимт ямааны дуудлаг болон үзэсгэлэн худалдааг жил бүр зохио байгуулсугай;

в)ямааг бруцеллөз, хамуу зэрэг өвчнөө урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арг хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

8.Түүхий эдийн гарал үүслийг тодорхойлолтыг тухайн сумын Засаг даргаа олгодог журам тогтоох асуудлыг судлан үзэ шийдвэрлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Сангийн сай Я.Очирсүх, аймгийн Засаг дарга нар даалгасугай.

9.Ноолуур, ямааны арьсыг экспорто гаргахад тавих төрийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаан туслах, давхар хяналт тавих хөдөлгөө өрнүүлж ажиллахыг холбогдох төрийн бу байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрь удирдлагад зөвлөсүгэй.

10.Энэ тогтоолын 5 дугаар заалтыг 200 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэ мөрдсүгэй

Монгол Улсын
Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГА

Дэд бүтцийн хөгжлийн
сайд бөгөөд Хөдөө аж ахуй,
үйлдвэрийн сайдын
үүрэг гүйцэтгэгч

Г.БАТХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашины зардал хэмнэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын дагуу албан тушаалын ба албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан (Монгол Улсын Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогчоос бусад)-ы өдөр тутмын ажил, үйлчилгээнд хэрэглэж байгаа суудлын автомашины зардлыг 1 километр явахад шаардагдах зардлаар тооцон, тухайн албан тушаалтанд сар тутам олгож байхаар тогтоосугай.

Хэрэв аль нэг байгууллагатай гэрээ хийж үйлчлүүлсэн бол сар бүрийн эцэст үйлчлэгч байгууллагатайгаа тооцоо хийж байх үүргийг тухайн албан тушаалтанд хариуцуулсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан албан тушаалын ба албан ажлын суудлын автомашины 1 километр явахад шаардагдах зардлыг энэ оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн 2000 оны төсөвт тусгагдсан хэмжээгээр тооцон олгох, цаашид жил бүрийн төсөв боловсруулахдаа хянан үзэж,

төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

3. Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны байгууллагуудын ажил, үйлчилгээнд хэрэглэж байгаа албан тушаалын, албан ажлын болон дуудлагын суудлын автомашины ашиглалтын байдалд энэ оны 4 дүгээр сард багтаан шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах, шаардлагатай бол дээрх тогтоолд өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газарт танилцуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаяр даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 2000 оны 3 сарын 15-нд Төрийн ордны 251 дүгээр өрөөнд үйлдэв. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Н. Жанцан даргалж, гишүүдэд Д. Дэмбэрэлцэрэн, Ж. Бямбажав, Ж. Амарсанаа /илтгэгч/, В. Удвал нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндэхүү оролцов.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэн С. Нарангэрэл, Н. Хайдав, Н. Баасанжав, Д. Чулуунжав, О. Жамбалдорж, Улсын Их

Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Р. Гончигдорж, А. Ганбаатар, Д. Лүндээжанцан, Ц. Нямдорж нар оролцов.

Нэг. Иргэн С.Нарангэрэл Үндсэн хуулийн Цэцэд 1999 оны 12 дугаар сарын 31-нд гаргасан өргөдөлдөө: « УИХ-аас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн дараахь заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

1/ . Монгол улсын үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Монгол улсад засгийн эрх бүх ард түмний мэдэлд байна" гэсэн заалтыг ноцтой зөрчжээ.



Энэ нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг УИХ-ын гишүүд 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын дарга Р.Гончигдоржид өргөн барьж, мөн өдрийн маргааш нь үдээс өмнө хэлэлцэж шууд баталсан, эл асуудал энэ удаагийн чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд огт тусгагдаагүй зэргээр нотлогдож байна.

2/ УИХ-ын гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхолыг илэрхийлнэ" гэж заасныг ноцтой зөрчсөн нь дараахь байдлаар нотлогдож байна.

а/ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшилцлийг хийх эрх УИХ-д суудалтай зөвхөн гурван намд байгаа гэж үзсэн нь өрөөсгөл юм.

б/ Өнөөгийн УИХ-д суудалтай улс төрийн намууд нийт иргэн, улсын ашиг сонирхол, үндэсний эрх ашгийг бүрэн төлөөлж чадахгүй байгаа билээ.

3/ Монгол Улсын Үндсэн хуульд УИХ яаран сандрэн, "хуйвалдааны" замаар нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг буюу иргэд "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" гэсэн заалтыг ноцтой зөрчжээ. УИХ-ын гишүүд энэхүү нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа сонгогчдынхоо санал хүсэлтийг огт авалгүй хийснээр нотлогдоно.

4/ Үндсэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг иргэд, сонгогчдод шүүн тунгаах цаг хугацааны ямарч боломж олгохгүйгээр УИХ хэлэлцэж баталсан нь Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд заасан "хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эрхэд" ноцтой халдаж зөрчжээ.

5/ УИХ Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт "Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг УИХ -ын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй саналаар батлана" гэж заасныг зөрчжээ. Энэ удаагийн Улсын Их Хурал хичнээн гишүүнтэй болсон, хэдэн гишүүн санал хураалтад оролцоноос үзэхэд тодорхой болж байгаа юм.

6/ Монгол Улсын Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц УИХ-д өргөн мэдүүлж болно" гэж заажээ.

Гэтэл УИХ энэ удаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц саналаа гаргах эрхийг зөрчжээ. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөлгүй өөрчлөлт оруулсан явдал Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн" гэж заасныг зөрчсөн хэрэг юм" гэжээ.

Иргэн С. Нарангэрэл Үндсэн хуулийн Цэцэд 2000 оны 3 дугаар сарын 13-нд гаргасан нэмэлт тайлбартаа:

"1/ Монгол улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг зөрчжээ. Энэ нь Үндсэн хуулийн Цэцээс санал аваагүй, Ерөнхийлөгчтэй зөвшилцөөгүй, сонгогчид, олон нийтээр хэлэлцүүлээгүй зэргээр нотлогдож байна.

2/ Иргэд болон улс төрийн бусад намын саналыг аваагүй нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна" гэж заасан эрхийг зөрчсөн байна.

3/ Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн утга агуулгаас үзэхэд "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгын талаархи саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно" гэж заасан байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаар УИХ-д өргөн мэдүүлэх эрхтэй болох нь тодорхой байна.

4/ УИХ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй саналаар батална" гэж заасныг зөрчсөн байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ирцийн бүрдэл хүрээгүй байхад УИХ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталсан байна.

5/ Нэмэлт, өөрчлөлт бүхэлдээ Үндсэн хуулийн 20 дугаар зүйл /Монгол Улсын Их хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална/, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг /Улсын Их



Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална/ зөрчжээ. Энэ нь:

а/ УИХ-ын чуулганы ирцийг бууруулсан өөрчлөлт Үндсэн хуульд оруулснаар УИХ-аас гаргах шийдвэрт нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн тусгахад сөргөөр нөлөөлөх эрх зүйн үндсийг тавьжээ.

б/ Нэмэлт өөрчлөлтөөр 50-иас доошгүй хоног хуралдах болсон нь УИХ-ын хууль тогтоох болон төлөөлөгчдийн байгууллагын /Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/ шинж нь алдагдах боллоо.

в/ 45 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ хэлэлцэж шийдвэрлэж чадахгүй нөхцөлд УИХ-ыг тарааж байхаар тогтсон нь төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ыг тогтворгүй болгож, улс төрийн аливаа сөрөг хүчин буюу төр засгийн эрх мэдлийг улайран булаалдагч улс төрийн хүчнүүд сонгуулийн үр дүнг бусниулахад ашиглах сиймхий буй болгожээ.

б/ Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур үндэс нь тус хуулийн 3 дугаар зүйл /Монгол Улсын төрийн байгуулал/ бүлгээс үзэхэд төрийн эрх мэдлийг хуваарилсанд оршино. Гэтэл эл үзэл баримтлалаас ухарч, хууль тогтоох /УИХ/ ба гүйцэтгэх /Засгийн газар/ эрх мэдлийг нэгтгэх алхам Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан өөрчлөн найруулгаар буй болж байна. Энэ нь угтаа Үндсэн хуулийн 20, 38 дугаар зүйлийн заалт зөрчигдсөнийг харуулж байна.

7/ Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан УИХ-ын гишүүнийг нууцаар саналаа гаргаж сонгох тухай нийтлэг үндэслэлтэй Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1, 26 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь /нууц санал хураалтыг ил болгосон/ зөрчилдөж байгаа юм. Түүнчлэн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчжээ. Энэ нь бас Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн төдийгүй УИХ төрийн эрх барих дээд байгууллага мөн гэсэн Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд харшилж байна." гэжээ.

Хоёр. Иргэн Н. Хайдав Үндсэн хуулийн цэцэд 1999 оны 12 сарын 28-нд гаргасан өргөдөлдөө: «Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь хууль санаачлагчдын хувьд санаачилгаа Үндсэн хуулийн Цэцэд уламжлахаар хязгаарлагдаж, Улсын Их Хуралд оруулах нь Үндсэн хуулийн Цэцийн онц эрхэд хамаарсан эрх мэдэл юм. Ийнхүү Үндсэн Хуулийн Цэцийн эрхэнд халдсан нь Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн хэрэг юм" гэжээ.

Иргэн Н.Хайдав Үндсэн хуулийн Цэцэд 1999 оны 12 сарын 28-нд гаргасан өргөдлийн тайлбартаа: « Үндсэн Хуулийн 68-р зүйлийн 1 дэх заалтыг авч үзвэл Үндсэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хууль санаачлагчдын санаачилга гаргах эрх мэдлийг хөндөөгүй бөгөөд харин хууль санаачлагчдын саналыг УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх эрхийг Үндсэн Хуулийг чандлан сахиулагч Үндсэн Хуулийн Цэцэд олгосон байна" гэжээ.

Гурав. Иргэн Н. Баасанжав Үндсэн хуулийн Цэцэд 1999 оны 12 дугаар сарын 28-нд гаргасан өргөдөл болон нэмэлт тайлбартаа: «Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль санаачлах, батлах эрхийг УИХ-ын гишүүдэд олгосон бөгөөд харин өөрчлөлтийн саналыг өргөн барих эрхийг Үндсэн хуулиар Үндсэн хуулийн Цэцэд олгожээ.

УИХ-ын тухай, УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын ба Дэгийн тухай хуулийг зөрчиж Үндсэн хуульдаа дур зоргоороо нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх заалт болон 70 дугаар зүйлийн 1 дэх заалттай зөрчилдөж байна" гэжээ.

Дөрөв. Иргэн Д.Чулуунжав Үндсэн хуулийн Цэцэд 2000 оны 1 сарын 7-ны өдөр гаргасан өргөдөлдөө: « Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд хугацааны хязгаарлалт (5 хоног, 7 хоног) тогтоох бусармаг гэхээр аргаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн зарчмыг төгс бус эрх болгож өөрчилжээ.

УИХ-ын үйл ажиллагааны бүх талыг хугацааны хязгаарлалтад оруулж 5 бэ 7 хоног өнгөрмөгц түүний эрхийг өөр субъект шилжүүлэн авч эдлэхээр хуульчилжээ.



УИХ-ын чуулах хугацааг 50 өдөр болгосон нь Үндсэн хуулийн 23-р зүйлийн 1-д "УИХ-ын гишүүн бол . . . нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлана" гэсэн заалтад харшилж байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд " . . . Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилж тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ" гэсэн нь Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1, 1 дүгээр зүйлийн 2-т харшлах юм. Нам, эвслийн бүлэг бүр дэд даргатай байхаар хийсэн өөрчлөлт нь Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 9,10-ыг зөрчжээ.

Үндсэн хуулийн ". . . Түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах" гэсэн Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд хамаарах чухал заалтыг мөн орхигдуулжээ. Энэ нь төрийн дээд өндөрлөгүүдийн харилцан хяналт тавих бүтэн системийн чухал нэгэн шинжийг тасдаж, төрийн машинд тавих шаардлага, хяналтын мөрөөр авах арга хэмжээг үгүйсгэж байна" гэжээ.

Иргэн Д.Чулуунжав Үндсэн Хуулийн цэцэд 2000 оны 1 сарын 7-ны өдөр гаргасан өргөдлийн тайлбартаа: «Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 2-т өмнө нь байсан "Түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах" гэсэн онц чухал хэсгийг мөн дагалдуулан хасаж, чингэснээр Ерөнхий сайдыг томилох, мөн Засгийн газрыг огцруулах тухай санал оруулах эрхийг Ерөнхийлөгчийн гараас бүрэн салгажээ.

Ингэснээр УИХ-ын гишүүн хүн нэгэн намын заавар, удирдамжийг ягштал сахигч, намын удирдлагын албат, хараат хүн болж хувирч байна. Гэтэл Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэж заасан.

Гэтэл саналыг илээр гаргуулах болсон нь Үндсэн хуулийн гол чухал зарчим, заалтын агуулгад харшилж, зөрчиж байна.

УИХ-ын дарга, дэд даргыг саналаа илээр гаргаж сонгох, дэд даргыг зөвхөн нам ба эвслийн бүлэг тус бүрээс сонгох тухай заасан нь намын бүлэгт ороогүй гишүүдийн хувьд хүний эрхийг зөрчсөн шийдэл болжээ. Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т

"Хүнийг . . . үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэж, мөн 16 дугаар зүйлийн 9-д "Монгол Улсын иргэн . . . төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй" гэж заасныг зөрчжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга бүрийг нягтлан үзээд өөрчлөх шаардлага байна гэж тогтвол дэлгэрэнгүй үндэслэл бүхий саналаа УИХ-д зөвхөн Цэц л өргөн мэдүүлэх учиртай. Үндсэн хуульд яг ингэж зааж, ийм механизмыг суулгаж өгсөн атал түүнийг УИХ -ын хууль санаачилсан гэгдэх гишүүд ноцтой зөрчжээ" гэжээ.

Тав. Монгол Улсын иргэн Н. Отгон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд 2000 оны 1 дүгээр сарын 20-нд гаргасан өргөдөлдөө:

«1. Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл бүх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" гэжээ. Гэтэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхдээ тойргийн сонгогчид-тойгоо уулзаж тэдний санаа бодлыг сонсоогүй нь дээрх заалтыг зөрчжээ.

2. Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1-д: "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно" гэж заасныг зөрчсөн байна гэж үзэж байна.

Зургаа. Иргэн О.Жамбалдорж Үндсэн хуулийн Цэцэд 2000 оны 1 дүгээр сарын 20-нд гаргасан өргөдөлдөө:

"1/ Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга гаргаад Улсын Их Хуралд оруулахын оронд Үндсэн хуулийн Цэцэд өгч хянуулах журам тогтоожээ. Ийнхүү Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгайлан авч үзэж, Үндсэн хуулиар хууль санаачлагчдын эрх мэдлийг тодорхой хэмжээгээр хязгаарлан тодорхойлжээ гэж үзэж болно. Гэтэл Улсын Их Хурал "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт"-ийг хууль санаачлагчдын шууд оруулснаар авч хэлэлцэн баталсан байна.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно" гэж заажээ. Улсын Их Хурал ард нийтийн санал асуулга явуулах асуудлыг шийдээгүй байж уг нэмэлт, өөрчлөлтийг батлан гаргасан нь Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзэх үндэстэй байна" гэжээ.

Долоо. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар ирүүлсэн тайлбартаа: "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт"-ийн талаар иргэн Н.Баасанжав, О.Жамбалдорж, С.Нарангэрэл, Д.Чулуунжав, Н.Хайдав нараас Үндсэн хуулийн Цэцэд гаргасан өргөдөлтэй холбогдуулан дурдсан тайлбарыг тогтоолуулж байна.

Дээр дурьдсан иргэдийн өргөдлөөс үзэхэд "Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн" гэх маргаан нь анхаарал татахуйц, бусад нь Цэцийн харъяалалд үл хамаарах асуудал гэж үзэж зөвхөн Цэцэд харъяалагдах асуудлаар тайлбар өгөх нь зүйтэй гэж үзэв.

Үндсэн хуулийн Цэцэд Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх заалтын талаар дараахь тайлбарыг өгч байна.

а/ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гагцхүү хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд түүнийг Улсын Их Хурал ямар ч дамжлагагүйгээр шууд хүлээн авч хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

б/ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Үндсэн хуулийн Цэц бие даан, тэгэхдээ санаачлагчийн санал авахгүйгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ саналыг хэлэлцэх эсэх

нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байхаар Үндсэн хуульд заажээ. Иймд хууль санаачлах эрх бүхий санаачлагчийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санаачилсан төслийг урьдчилан хүлээн авах, хэлэлцэх, уг төслийн талаар санал дүгнэлт гаргах, түүнийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зохистой эсэхийг шийдвэрлэх эрхийг Цэцэд Үндсэн хуулиар олгоогүй байна.

Дээр дурдсан баримт үндэслэлд тулгуурлан Монгол Улсын Их хурал Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг Үндсэн хуулийн Цэцэд оруулж байна" гэжээ.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Нямдорж " ... санаачилсан бол дамжлагагүйгээр, өөрөөр хэлбэл Цэцээр оруулахгүйгээр шууд Их Хурал аваад хэлэлцэх эрхтэй, тэр санал гэдэг нь шууд Цэцэд хамааралтай заалт, Цэц хуулийн маргааныг хэлэлцэх явцад Үндсэн хуулийн дотор зөрчил байнаа, ийм асуудлыг ингэж цэгцлээ, ингэж өөрчлөө гэх юм бол тэр тухай санал боловсруулаад ... Улсын Их Хуралд шууд оруулнаа" гэжээ. Түүнчлэн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн нэг хэсэг, энэ нь Үндсэн хуулийн хяналт тавих харъяаллын асуудал биш юмаа гэж ойлгож байгаа гэжээ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Р.Гончигдорж: " Хууль санаачлах гэдэг бол заавал хэлэлцэх үүргийг хууль тогтоох байгууллагад бий болгодог ийм төсөл, хуулийн санал гэдэг бол ердийн хуулиудын хувьд хууль санаачлагчаар дамжуулж, Улсын Их Хурал руу хууль санаачлагдсан хэлбэршил рүү орж байж хэлэлцдэг зүйл. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн санал нь харин Цэцийн зүгээс шууд Улсын Их Хуралд өргөн баригдахаар ингэж тогтоогдсон байна" гэжээ.



ХЯНАВАЛ:

1. Монгол Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2; далдугаар зүйлийн 1 дэх заалтад нийцээгүй байна.

2. Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн жараннаймдугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн Цэцэд олгоогүй байна.

3. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2; 68 дугаар зүйлийн 1; 70 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна гэсэн иргэн С.Нарангэрэл, Н.Хайдав, Н.Баасанжав, Д.Чулуунжав, Н.Отгон, О.Жамбалдорж нарын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ гаргах нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт" нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш

байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мон", жараннаймдугаар зүйлийн 1-д заасан "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно", далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2, жараннаймдугаар зүйлийн 1, далдугаар зүйлийн 1 дэх хэсгээс бусад зүйл, заалтын талаар иргэдээс гаргасан гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.

3. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Ж.БЯМБАЖАВ

Ж.АМАРСАНАА

В.УДВАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг
эрхлэх газрын харьяа
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806
320407